

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024//113/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секьюритиз Аудит" ХХК

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл.....
  - 4.2 Материаллаг байдал.....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/170.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Д.МӨНХЗУЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 83,2 хувиар хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

010000004

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1.00	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	281,074,977.83	263,052,457.67
2.00	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	84,652,306.19	29,561,227.43
8.00	Банкинд байгаа бэлэн мөнгө	84,652,306.19	29,561,227.43
9.00	Төгрөг	84,652,306.19	29,561,227.43
10.00	Төрийн сангийн харилцах	84,652,306.19	29,561,227.43
27.00	АВЛАГА	19,602,756.00	6,091,616.00
29.00	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,122,200.00	6,091,616.00
34.00	Бусад авлага	480,556.00	(0.00)
35.00	Байгууллагаас авах авлага	480,556.00	-
60.00	БАРАА МАТЕРИАЛ	176,819,915.64	227,399,614.24
61.00	Түүхий эд материал	118,788,281.64	131,285,979.74
62.00	Тусгай зориулалттай материал	26,976,533.85	32,250,558.85
63.00	Эм боох материал	91,811,747.79	99,035,420.89
66.00	Хангамжийн материал	58,031,634.00	96,113,634.50
67.00	Бичиг хэргийн материал	1,973,100.00	584,500.00
68.00	Аж ахуйн материал	51,759,015.00	94,819,274.50
69.00	Сэлбэг хэрэгсэл	726,000.00	-
72.00	Хүнсний материал	2,926,919.00	426,360.00
73.00	Бусад хангамжийн материал	646,600.00	283,500.00
86.00	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	930,755,298.46	1,260,383,117.01
106.00	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	930,755,298.46	1,260,383,117.01
108.00	Биет хөрөнгө	907,875,298.46	1,237,503,117.01
109.00	Барилга, байгууламж	616,524,255.73	964,419,846.73
110.00	Хуримтлагдсан элэгдэл	(51,922,126.46)	(71,111,535.14)
111.00	Авто тээврийн хэрэгсэл	72,780,000.00	137,700,000.00
112.00	Хуримтлагдсан элэгдэл	(47,591,333.42)	(61,069,666.80)
113.00	Машин, тоног төхөөрөмж	349,306,360.44	376,842,786.44
114.00	Хуримтлагдсан элэгдэл	(111,276,990.51)	(181,095,486.02)
115.00	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,603,065.50	83,503,065.50
116.00	Хуримтлагдсан элэгдэл	(7,104,532.82)	(17,658,493.66)
122.00	Бусад үндсэн хөрөнгө	5,300,000.00	5,300,000.00
123.00	Хуримтлагдсан элэгдэл	-	(530,000.04)
125.00	Номын фонд	1,256,600.00	1,202,600.00
126.00	Биет бус хөрөнгө	22,880,000.00	22,880,000.00
129.00	Бусад биет бус хөрөнгө	22,880,000.00	22,880,000.00
137.00	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,211,830,276.29	1,523,435,574.68
138.00	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	30,000.00	30,000.00
139.00	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,000.00	30,000.00
164.00	Өглөг	30,000.00	30,000.00
166.00	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,000.00	30,000.00
214.00	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,211,800,276.29	1,523,405,574.68
215.00	Засгийн газрын хувь оролцоо	1,211,800,276.29	1,523,405,574.68
216.00	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	481,147,295.44	481,147,295.44
217.00	Өмч: -Төрийн өмч	481,147,295.44	481,147,295.44
223.00	Хуримтлагдсан үр дүн	642,624,308.80	954,229,607.19
224.00	Өмнөх үеийн үр дүн	642,624,308.80	642,624,308.80
225.00	Тайлант үеийн үр дүн	-	311,605,298.39
227.00	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,028,672.05	88,028,672.05
231.00	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,211,830,276.29	1,523,435,574.68

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,545,375,404.80	1,046,420,447.02
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,027,659,764.80	406,525,367.63
77	Нийтлэг татварын бус орлого	1,027,659,764.80	406,525,367.63
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	194,532,390.59	1,050,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	194,532,390.59	1,050,000.00
92	Бусад орлого	-	2,115,700.00
93	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	734,806,705.49	359,735,870.00
94	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	98,320,668.72	43,623,797.63
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	517,715,640.00	639,895,079.39
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,752,300.00	38,580,500.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,752,300.00	38,580,500.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	491,963,340.00	601,314,579.39
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас	491,963,340.00	601,314,579.39
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	521,360,200.66	734,815,148.63
148	УРСГАЛ ЗАРДАЛ	521,360,200.66	734,815,148.63
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,822,592.06	734,165,630.68
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	299,935,287.04	375,216,877.69
151	Цалин	242,228,828.67	235,241,223.55
152	Нэмэгдэл цалин	33,448,508.84	110,638,679.54
153	Унаа хоолны хөнгөлөлт	1,719,000.00	3,874,000.00
154	Урамшуулал	22,538,949.53	25,462,974.60
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,207,157.13	52,086,152.96
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	28,250,331.69	36,684,932.48
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,113,918.89	4,315,874.44
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,417,055.10	3,399,899.54
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	429,544.81	694,711.59
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,996,306.64	6,990,734.91
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,397,599.00	36,653,082.05
165	Гэрэл цахилгааны зардал	3,141,871.00	3,888,976.35
166	Түлш, халаалтын зардал	13,003,787.00	30,681,365.70
167	Цэвэр, бохир усны зардал	251,941.00	2,082,740.00
170	Хангамж, бараа материалын зардал	33,134,390.78	40,333,726.00
171	Бичиг хэргийн материал	2,383,200.00	4,262,150.00
172	Тээвэр, шатахууны зардал	25,602,015.00	33,276,076.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	505,000.00	213,000.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	2,581,060.00	1,832,500.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	140,440.00	-
177	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	750,000.00
178	Бараа материал актасны зардал	1,922,675.78	-
181	Нормативт зардал	19,288,830.32	61,413,062.03
182	Эм	9,830,604.32	46,313,903.03
183	Хоол	9,458,226.00	15,099,159.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	7,445,010.00	4,018,700.00
186	Багаж хэрэгсэл	194,990.00	1,046,100.00
187	Тавилга	198,000.00	-
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,109,020.00	1,391,000.00

189	Урсгал засвар	2,943,000.00	1,581,600.00
190	Томилолт, зочны зардал	2,443,500.00	3,898,000.00
192	Дотоод томилолтын зардал	2,443,500.00	3,898,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	652,801.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	432,000.00
197	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	79,500.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	70,000.00
199	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33,000.00
201	Газрын төлбөр	-	38,301.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	100,970,817.79	159,893,228.95
210	Бараа үйлчилгээний бусад зардал	16,554,183.00	40,421,386.98
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,416,634.79	119,471,841.97
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,537,608.60	649,517.95
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	649,517.95
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	649,517.95
247	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	2,537,608.60	-
250	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,537,608.60	-
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,024,015,204.14	311,605,298.39
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	14,396,227.81	-
281	Үнэ төлбөргүй гарсан зардал	14,396,227.81	-
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(14,396,227.81)	-
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1,009,618,976.33	311,605,298.39

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	671,145,440.00	656,091,363.39
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,165,700.00
78	Нийтлэг татварын бус орлого	-	3,165,700.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,050,000.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,050,000.00
92	Бусад орлого	-	2,115,700.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	671,145,440.00	652,925,663.39
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,752,300.00	38,580,500.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,752,300.00	38,580,500.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	645,393,140.00	614,345,163.39
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	645,393,140.00	614,345,163.39
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	503,850,723.56	711,182,442.15
148	УРСГАЛ ЗАРДАЛ	503,850,723.56	711,182,442.15
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	501,313,114.96	710,532,924.20

150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	299,185,668.52	379,940,682.33
151	Үндсэн цалин	201,768,776.88	241,598,937.19
152	Нэмэгдэл	67,814,710.96	109,193,770.54
153	Унаа хоолны хөнгөлөлт	1,705,000.00	3,685,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	27,897,180.68	25,462,974.60
157	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	39,953,676.04	47,362,348.32
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	28,680,826.54	33,322,472.09
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,113,918.89	3,920,290.87
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,397,055.10	3,083,432.68
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	461,895.23	635,684.88
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,299,980.28	6,400,467.80
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	22,863,691.40	36,653,082.05
165	Гэрэл цахилгааны зардал	3,141,871.00	3,888,976.35
166	Түлш, халаалтын зардал	18,540,999.40	30,681,365.70
167	Цэвэр, бохир усны зардал	1,180,821.00	2,082,740.00
170	Хангамж, бараа материалын зардал	31,741,496.00	39,031,326.00
171	Бичиг хэрэг	2,861,300.00	3,506,250.00
172	Тээвэр, шатахуун	25,602,015.00	33,276,076.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	978,800.00	213,000.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,999,591.00	2,036,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,790.00	-
181	Нормативт зардал	55,465,293.00	41,585,739.50
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,588,844.00	28,987,139.50
183	Хоол, хүнс	11,876,449.00	12,598,600.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	46,137,790.00	45,947,000.00
186	Багаж техник хэрэгсэл	6,615,990.00	25,254,400.00
187	Тавилга	1,800,000.00	-
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	23,454,000.00	4,451,000.00
189	Урсгал засвар	14,267,800.00	16,241,600.00
190	Томилолт, зочны зардал	2,443,500.00	3,898,000.00
192	Дотоод албан томилолт	2,443,500.00	3,898,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	-	652,801.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432,000.00
197	Даатгалын үйлчилгээ	-	79,500.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	70,000.00
199	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
201	Газрын төлбөр	-	38,301.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	3,522,000.00	115,461,945.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	3,522,000.00	115,461,945.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,537,608.60	649,517.95
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	649,517.95
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	649,517.95
244	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,537,608.60	-
247	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,537,608.60	-
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)	167,294,716.44	(55,091,078.76)
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	118,764,703.00	-
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,764,703.00	-
263	Дотоод эх үүсвэрээр	118,764,703.00	-
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	118,764,703.00	-
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(118,764,703.00)	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	48,530,013.44	(55,091,078.76)
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,122,292.75	84,652,306.19
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,652,306.19	29,561,227.43

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ҮР ДҮН	Засгийн газрын хувь оролцооны НИЙТ ДҮН
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	458,267,295.4	78,916,746.0	31,005,404.9	568,189,446.4
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	458,267,295.4	78,916,746.0	31,005,404.9	568,189,446.4
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал	-	-	(9,119,439.3)	(9,119,439.3)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	481,147,295.4	88,028,672.1	642,624,308.8	1,211,800,276.3
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	481,147,295.4	88,028,672.1	642,624,308.8	1,211,800,276.3
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	481,147,295.4	88,028,672.1	642,624,308.8	1,211,800,276.3
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал	-	-	311,605,298.4	311,605,298.4
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	481,147,295.4	88,028,672.1	954,229,607	1,523,405,574.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	84,652,306.19	(84,652,306.19)	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	814,224,300.00	710,532,924.20	103,691,375.80	87.3
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	814,224,300.00	710,532,924.20	103,691,375.80	87.3
4	Бараа, үйлчилгээний зардал	814,224,300.00	710,532,924.20	103,691,375.80	87.3
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,568,300.00	379,940,682.33	87,627,617.67	81.3
6	Үндсэн цалин	299,061,900.00	241,598,937.19	57,462,962.81	80.8
7	Нэмэгдэл	117,034,100.00	109,193,770.54	7,840,329.46	93.3
8	Унаа, болон бусад нөхөн олговор	104,400.00	3,685,000.00	(3,580,600.00)	
9	Урамшуулал	51,367,900.00	25,462,974.60	25,904,925.40	49.6

11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,784,700.00	47,362,348.32	12,422,351.68	79.2
12	Тэтгэврийн даатгал	41,439,500.00	33,322,472.09	8,117,027.91	80.4
13	Тэтгэмжийн даатгал	4,296,500.00	3,920,290.87	376,209.13	91.2
14	ҮОМШӨ ний даатгал	3,437,800.00	3,083,432.68	354,367.32	89.7
15	Ажилгүйдлийн даатгал	859,800.00	635,684.88	224,115.12	73.9
16	Эрүүл мэндийн даатгал	9,751,100.00	6,400,467.80	3,350,632.20	65.6
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,280,500.00	36,653,082.05	627,417.95	98.3
18	Гэрэл цахилгаан	4,756,900.00	3,888,976.35	867,923.65	81.8
19	Түлш, халаалт	30,003,600.00	30,681,365.70	(677,765.70)	102.3
20	Цэвэр, бохир ус	2,520,000.00	2,082,740.00	437,260.00	82.6
22	Хангамж, бараа материалын зардал	39,595,200.00	39,031,326.00	563,874.00	98.6
23	Бичиг хэрэг	3,874,700.00	3,506,250.00	368,450.00	90.5
24	Тээвэр (шатахуун)	33,288,300.00	33,276,076.00	12,224.00	100.0
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	395,000.00	213,000.00	182,000.00	53.9
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,037,200.00	2,036,000.00	1,200.00	99.9
30	Нормативт зардал	42,715,100.00	41,585,739.50	1,129,360.50	97.4
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	29,013,100.00	28,987,139.50	25,960.50	99.9
32	Хоол, хүнс	13,702,000.00	12,598,600.00	1,103,400.00	91.9
34	Эд хогшил худалдан авах	46,774,700.00	45,947,000.00	827,700.00	98.2
35	Багаж, техник, хэрэгсэл	25,974,700.00	25,254,400.00	720,300.00	97.2
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,500,000.00	4,451,000.00	49,000.00	98.9
38	Урсгал засвар	16,300,000.00	16,241,600.00	58,400.00	99.6
39	Томилолт, зочны зардал	3,955,500.00	3,898,000.00	57,500.00	98.5
41	Дотоод албан томилолт	3,955,500.00	3,898,000.00	57,500.00	98.5
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,085,000.00	652,801.00	432,199.00	60.2
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	432,000.00	432,000.00	-	100.0
46	Даатгалын үйлчилгээ	93,000.00	79,500.00	13,500.00	85.5
47	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	70,000.00	130,000.00	35.0
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	33,000.00	17,000.00	66.0
50	Газрын төлбөр	50,000.00	38,301.00	11,699.00	76.6
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	260,000.00	-	260,000.00	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал	115,465,300.00	115,461,945.00	3,355.00	100.0
54	Бараа үйлчилгээний бусад зардал	115,465,300.00	115,461,945.00	3,355.00	100.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	654,018,400.00	653,975,663.39	42,736.61	100.0
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	640,438,300.00	-	640,438,300.00	-
99	Улсын төсвөөс санхүүжих	640,438,300.00	-	640,438,300.00	-
##	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,580,100.00	38,580,500.00	(25,000,400.00)	284.1
##	Орон нутгийн төсвөөс	13,580,100.00	38,580,500.00	(25,000,400.00)	284.1
##	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	614,345,163.39	(614,345,163.39)	
##	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	614,345,163.39	(614,345,163.39)	
##	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,050,000.00	(1,050,000.00)	
##	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,050,000.00	(1,050,000.00)	
##	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	84,652,306.19	(84,652,306.19)	
##	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,561,227.43	(29,561,227.43)	
##	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	-	100.0
##	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
##	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.0
##	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Иргэн бүрт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 5 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 87,3 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 21 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 93,0 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 83,0 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 311,605.2 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	84,652.3	29,561.2	-55,091.0
<b>Авлага</b>	19,122.2	6,091.6	13,030.5
<b>Урьдчилгаа</b>			
<b>Бараа материал</b>	176,819.9	227,399.6	47,579.6
<b>Үндсэн хөрөнгө</b>	930,755.2	1,260,383.1	329,627.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,211,830.2</b>	<b>1,523,435.5</b>	<b>311,605.2</b>
<b>Өр төлбөр</b>	30.0	30.0	
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	481,147.3	481,147.3	
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	642,624.3	954,229.6	
<b>Дахин үнэлгээний зөрүү</b>	88,028.6	88,028.6	
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,211,830.2</b>	<b>1,523,435.5</b>	<b>311,605.2</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 55,091.1 мянган төгрөгөөр буурсан нь зарцуулалттай байна.

Бараа материал дансны үлдэгдэл 47,579.6 мянган төгрөгөөр өссөн нь:

- Улсын төсвийн хөрөнгөөр 111,515.5 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн бараа материал, бичиг хэргийн материал, сэлбэг хэргэсэл, тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материал худалдан авсан.
- Хандиваар 27,352.6 мянган төгрөгийн эм, эмнэлэгийн хэрэгсэл, боох материал, 15,000.0 мянган төгрөгийн аж ахуйн материал Аймгийн эрүүл мэндийн газраас, үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Бараа материал данснаас байгууллагын үйл ажиллагаанд 131,593.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Төв аймгийн Бүрэн сумын ИТХ-н 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолоор 5,562.6 мянган төгрөгийн тусгай зориулалт, хангамжийн материал актлан устгасан байна.

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн дутуу 6,091.6 мянган төгрөгийн авлагатай бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 1,523,435.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 311,605.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр тавилга тоног төхөөрөмж худалдан авсан, мөн хандиваар хүлээж авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 22,149.8 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 68,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж улсын төсвийн хөрөнгөөр, 11,840.2 төгрөгний тоног төхөөрөмж Эрүүл мэндийн газраас, орон нутгийн сангаас 100,000.0 мянган төгрөгийн барилга хандиваар тус тус хүлээн авсан.
- 247,895.5 мянган төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр их засвар хийж капиталжуулсан.
- Төв аймгийн Бүрэн сумын ИТХ-н 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолоор машин тоног төхөөрөмж 2,406.2 мянган төгрөг, ном 54.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,150.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 3,080.0 нийт 6,687.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж хассан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 800,644.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 13,580.1 мянган төгрөг нийт зарлагыг 814,224.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 814,224.3 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 814,224.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 800,644.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 13,580.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 814,224.3 мянган төгрөг байна. Орон нутгийн төсвийг 1 удаа тодотгон 25,000.0 мянган төгрөгийг нэмэлтээр санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 671,952.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 37,930.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, нийт 710,532.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 710,532.9 мянган төгрөг буюу 87,3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 103,691.3 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин үндсэн болон нэмэгдэл цалин 87,627.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардлыг 649.5 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 563.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,129.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 827.7 мянган төгрөгөөр, бусад зардлыг 432.1 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлыг 12,422.3 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	71802 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
81603	Үндсэн үйл ажиллагааны зардал	155,447.9	152,057.4	3,390.4	97,8%
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	84,652.3	83,788.4	863.8	99%
80302	1 иргэнд ноогдох номативт зардал	534,543.6	435,756.0	98,787.5	81,5%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	38,580.5	37,930.9	649.5	98,3%
83601	Нэмэлт санхүүжилт	1,000.0	1,000.0		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд орон нутгийн төсвийн нэмэлт санхүүжилт 25,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилт дансаар гүйлгээ хийсэн.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт**

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71602-81603	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны зардал	97,8%	155,447.9	152,057.4
2	71602-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	99%	84,652.3	83,788.4
3	71602-80302	2023-12-31	1 иргэнд ноогдох нормативт зардал	81,5%	534,543.6	435,756.0
4	71602-80111	2023-12-31	Төрийн өмчит барилгын тогтмол зардал	98,3%	38,580.5	37,930.9
5	71602-83601	2023-12-31	Нэмэлт санхүүжилт	100%	1,000.0	1,000.0

1 иргэнд ноогдох нормативт зардал арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь орон тоо дутуу байгаатай холбоотой байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас тендэрт шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг. Хүнсний бараа материалыг тендэрт шалгарсан Өгөөмөр ХХК-с худалдан авалт хийдэг. Шатахууныг Дархан НИК ХХК-с гэрээгээр авдаг.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 680,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 13,600.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,900.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн

бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 148 мэдээллийг байршуулж 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн газрын эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад хөрөнгийн болон зардлын данстай холбоотой 26,493.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 3 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ Биелэлт
----------	------------------------	-------------------------------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Акт</b>					
<b>Албан шаардлага</b>					100
<b>Зөвлөмж</b>	3	29,732.7	3	29,732.7	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>29,732.7</b>	<b>3</b>	<b>29,732.7</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,493.8 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 810.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 25,629.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Зардлын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Томилолтын зардалд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 810.0 мянган төгрөгийн зардал гаргасан зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн, мөн "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

#### 5.3 Зөвлөмж

1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Барилга байгууламжинд хувийн хэрэг хөтлөх, мөн 25,493.7 мянган төгрөгийн зөрүү байгааг тодруулах. Энэ нь Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 71 тоот тушаалаар батлагдсан журмын 1-р заалт барилга байгууламж ашиглалт, өргөтгөл шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх журмыг мөрдөж ажиллаагүй зөрчил гарсан байна

##### Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомж, тушаал зааврын дагуу бүртгэлийг хөтлөж хэвших

2. Зардлын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Авто тээврийн хэрэгсэлд хувийн хэрэг нээж нийт явсан км, зай хураагуур, сэлбэг хэрэгсэл шахатууны нормыг мөрдөөгүй. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 тоот тушаалын 1-5 р хавсралтаар батлагдсан нормыг мөрдөж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Холбогдох хууль тогтоомж, тушаал зааврын дагуу бүртгэлийг хөтлөж хэвших

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардал анхан шатны баримтын бүрдэл хангаагүй	1	810.0	1	810.0								
Барилга байгууламжинд хувийн хэрэг хөтлөх, мөн зөрүү байгааг тодруулж жилийн эцэст тайлагнах	1	25,493.7					1	25,493.7				
Авто тээврийн хэрэгсэлд хувийн хэрэг нээж нийт явсан км, зай хураагуур, сэлбэг хэрэгсэл шатахууны нормыг мөрдөх	1	136.1					1	136.1				
Дүн	3	26,493.8	1	810.0			2	25,629.8				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)